

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/9/СТА-ТТЗ

| | | |
|---|------------------------------|--|
| Цахим хуудас: www.audit.mn Сайншанд хот 2019 он | Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа | |
| | Утас: 70522734 | Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Ц.Лүндэгмаа | |
| | Утас: 70523020 | Цахим хаяг: Lundegmaa.Ts@audit.gov.mn |
| | Аудитор: О.Нарангарав | |
| | Утас: 70523020 | Цахим хаяг: Narangarav.O@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | | |
|---------|--|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 5 |
| 2.1. | Оршил..... | 5 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 6 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 7 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 8 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 9 |
| 2.8.1 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар | 9 |
| 2.8.2 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар | 9 |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .. | 11 |
| 2.10. | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 12 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл..... | 13 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 13 |
| 2.13. | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:..... | 13 |
| 2.14 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 14 |
| 3 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 15 |
| 3.1 | Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН..... | 15 |
| 3.2 | Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН | 17 |
| 3.3 | Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 20 |
| 3.4 | Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН..... | 24 |
| 3.5 | Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН | 25 |

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.25 № 1-б/350.

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ДУЛАМ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дэлгэрэх сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчийн 6 байгууллага, 3 сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчилгүй, 1 хязгаарлалттай, 1 санал дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт авсан байна. ТШЗ-ийн 1 тайлан, 3 санг түүврийн аудитад хамруулсан.

Сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагууд нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй болно. Эдгээр байгууллагуудын 2018 оны төсвийн нийт гүйцэтгэл 290.2 сая төгрөг буюу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн нийт гүйцэтгэл /1,245.9 сая төгрөг/-ийн 23.3 хувийг эзэлж байна.

Сумын Засаг даргын тамгын газрын тайланг цаг хугацааны хязгаарлалтад оруулж санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тайланд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлэв.

Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт авсан.

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 26.6 сая төгрөгөөр тогтоосон. Төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн зөрчил нь 150.0 сая төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 5.6 дахин давсан байна.

Үүрэг, хариуцлага

Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Д.Дулам-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.21-наас 2019.03.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.05-ны өдрийн 01/53 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дэлгэрэх сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дэлгэрэх сумын Засаг дарга нь “Засгийн газраас эрх нь шилжиж ирсэн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, сум, байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсөв болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төсвийн захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээнд Дэлгэрэх сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтийн албаны бодлого
2. Хяналт шинжилгээ, мэдээлэл боловсруулалт
3. Хууль зүйн салбарын нийлүүлэх ажил үйлчилгээ
4. Батлан хамгаалах ажил үйлчилгээ
5. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээ

6. Санхүү, төрийн сангийн ажил үйлчилгээ
7. Худалдан авах ажиллагаа
8. Нийгмийн салбарын ажил үйлчилгээ
9. Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, газрын харилцаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлийн ажил үйлчилгээ

Дэлгэрэх сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд
- Сангийн сайд болон бусад сайдын тушаал шийдвэрүүд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Дэлгэрэх сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр | | | | |
|---|------------------------------|---|-------------|----------------|---------------------|----------------------|
| | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрлэсэн | Итгэл үзүүлсэн | Гэрээгээр хийлгэсэн | Аудитад хамрагдаагүй |
| 1 | Төсвийн шууд захирагч | 4 | 2 | - | - | - |
| 2 | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 1 | 3 | - | - | - |
| | Дүн | 5 | 5 | - | - | - |

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дэлгэрэх сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дэлгэрэх сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дэлгэрэх сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дэлгэрэх сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт орлого, зарлагын дүнгээс их байгаатай холбоотой юм.

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны нийт хөрөнгө 2,659,165.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 26,591.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн явцад нэгтгэл тайланд хамрагдах байгууллагуудын алдаа зөрчлийн тархалтын байдлыг тодорхойлохтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Дэлгэрэх сумын Засаг даргын болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 149,800.0 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 315,957.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 315,758.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Дэлгэрэх сумын ЕБС тайлант онд түлш нүүрс, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд нийт 81,641.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан. ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин ХАА-ны төлөвлөгөө хийгээгүй, худалдан авах ажил үйлчилгээг нийтэд зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглэж гүйцэтгэгчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж ХАА-ны хууль зөрчсөн, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Шийдэл:

Алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

Асуудал 2: Төсвийн өмнө хүлээсэн биелэлт

Дэлгэрэх сумын ЗДТГ болон ИХТ нь 2018 оны санхүүгийн тайлангаа аудитын байгууллагуудад ирүүлээгүй нь төсвийн тухай хууль зөрчсөн байна.

Шийдэл:

Сумын ЗДТГ-т дүгнэлт өгөхөөс татгалзсан, ИТХ-ын төсвийн захирагчид хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

| № | Залруулгын товч утга | Мөнгөн дүн (мянган төгрөгөөр) | Үүнээс: Залруулгын ангилал | | | |
|------------|--|-------------------------------|---|--|--|---|
| | | | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой | Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой |
| 1 | Үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд байгууллагуудын нэгтгэл хийхдээ дансны ангилалыг буруу бүртгэж тайлагнасан байна. | 311,914.6 | - | 311,914.6 | - | - |
| Дүн | | 311,914.6 | - | 311,914.6 | - | - |

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| № | Шийдэл | Тоо | (мянган төгрөгөөр) | |
|------------|---|----------|--------------------|---------|
| | | | Дүн | Тайлбар |
| 1 | Зөвлөмж өгсөн | 0 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 2 | 498.5 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| Дүн | | 2 | 498.5 | |

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

Санхүүгийн нэгтгэсэн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудын нийт 311,914.6 мянган төгрөгийн орлого, зарлагын дансыг буруу ангилан бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Сангийн сайдын 2015 оны 55-р тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.2.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Нөхөн сэргээлтийн сангаас 2018 онд барьцаа хөрөнгө байршуулсан байгууллагаас 3 компани нийт 5,500.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгөө буцааж авахгүй сумын тохижилтын үйл ажиллагаанд зарцуулах эрх олгосны дагуу сумын Засаг даргын 3 удаагийн захирамжаар Хавар намрын аян зохион байгуулах ажилд нийт 5,900.0 мянган төгрөгийн гүйлгээг хийж хандивын дүнгээс 400.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн.

2.8.2.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Нөхөн сэргээлтийн сангаас 2017 онд хавар намрын аян зохион байгуулах ажилд хөрөнгө зарцуулахдаа хувь хүнээс ХХОАТ-ын тооцоог суутгасан боловч гүйлгээг хийгээгүй үлдээж 98.5 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнасан боловч тайлант онд өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Өр төлбөрийг барагдуулах албан шаардлага өгсөн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нөхөн сэргээлтийн сан дансанд байршуулсан хөрөнгийг тайлант хугацааны үр дүн гэж тайлагнан, хандивласан барьцаа хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Иймд дараагийн аудитаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниас үйл ажиллагаа явуулсан тухайн жилийн эцэст байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор барьцаанд байршуулсан хөрөнгийг өр төлбөрөөр бүртгэж,

хандивласан барьцаа хөрөнгийг ЗДТГ-ын нэмэлт дансанд орлого хүлээн зөвшөөрч тайлагнах асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дэлгэрэх сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,383,817.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,584,346.0 мянган төгрөг буюу 99.5 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,246,017.8 мянган төгрөг буюу 90.0 хувьтай байгаа нь татварын орлого нийт дүндээ тасарч, төсөвт байгууллагуудын бараа үйлчилгээний зардал хэмнэлттэй гарсан нь шалтгаалжээ

Татварын орлогын биелэлт 42,082.9 мянган төгрөг буюу 96.6 хувьтай, 1,465.9 мянган төгрөгөөр тасарсан байна. Орлого тасрахад дараах нөхцөл байдлыг:

Үйл ажиллагааны орлогын албан татвар: 4,506.5 мянган төгрөгөөр тасарсан нь орох боломжгүй орлогыг тодотголоор нэмж тодотгосонтой,

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: 780.0 мянган төгрөгөөр тасарсан нь иргэд элс хайрга ашиглах нь урьд оноос багассантай.

Хүү торгуулийн орлого: 150.0 төгрөгөөр тасарсан нь Цагдаа торгууль бичихгүй дээд газартаа орлогыг биелүүлж байгаатай тус тус холбоотой гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Сумын татварын орлогыг 43,248.8 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 650.0 мянган төгрөгөөр нийт орлогыг 44,048.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 888,294.7 мянган төгрөг, ОНХСангийн санхүүжилт 74,613.2 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс авах татаас санхүүжилт 252,206.0 мянган төгрөгөөр нийт төсвийн орлогыг 1,259,162.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын төсвийг 46,600.2 мянган төгрөг, ЗДТГ 246,654.6 мянган төгрөг, ОНХСан 74,613.2 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагын шилжүүлэг 888,294.7 мянган төгрөг буюу нийт төсвийн зарлагыг 1,259,162.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Нөхөн сэргээлтийн сангийн орлого зарлагыг 26,961.0 мянган төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 97,694.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

| | Төлөвлөгөө /мян.төг/ | Гүйцэтгэл /мян.төг/ | Зөрүү /дууу + , илүү - / | Хувь |
|--------------------------------|-------------------------|------------------------|-----------------------------|-------------|
| ХХОАТ | 29,205.80 | 24,911.36 | 4,294.44 | 85.3 |
| Үйл ажиллагааны орлогын татвар | 950.00 | 1,162.07 | (212.07) | 122.3 |
| Бусад орлогын татвар | 28,255.80 | 23,749.29 | 4,506.51 | 84.1 |
| Бууны татвар | 1,740.00 | 1,912.00 | (172.00) | 109.9 |
| УТХураамж | 4,400.00 | 4,189.73 | 210.27 | 95.2 |
| Хог хаягдлын хураамж | 3,248.00 | 4,104.00 | (856.00) | 126.4 |
| ТТАМАТөлбөр | 880.00 | 100.00 | 780.00 | 11.4 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 3,775.00 | 6,429.01 | (2,654.01) | 170.3 |
| ҮХХ борлуулсны орлого | 150.00 | 436.80 | (286.80) | 291.2 |
| Бусад орлого /хүү торгууль/ | 150.00 | - | 150.00 | - |
| Дүн | 43,548.80 | 42,082.90 | 1,465.90 | 96.6 |

Сумын ИТХ болон ЗДТГ-ын төсвийн гүйцэтгэл 290,231.6 мянган төгрөг буюу 98.0 хувьтай, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 875,294.4 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна.

Аймгаас 252,206.0 мянган төгрөгийн татаас санхүүжилт авч, сумын ЗДТГ, ИТХ зарцуулаагүй үлдэгдэл 1,276.8 мянган төгрөгийг аймгийн төсөвт, тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн хэмнэлт 14,069.7 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус татан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дэлгэрэх сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд 2018 оны 3-р улирлын байдлаар аудит хийгдсэн бөгөөд аудитаар нийт 87.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 87.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 67.8 хувь буюу 315,758.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 17.6 хувь буюу 82,140.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 14.6 хувь буюу 67,859.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

(мянган төгрөг)

| № | Байгууллагын ангилал | Илрүүлэлт | | | | | | Залруулга | |
|---|----------------------|-----------|------------------|----------|------------------|-----------|------------------|-----------|------------------|
| | | Зөрчил | | Алдаа | | Бүгд дүн | | Тоо | Дүн |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | ТТЗ | 2 | 498.5 | 3 | 315,458.9 | 5 | 315,957.4 | 3 | 315,458.9 |
| 2 | ТШЗ | 7 | 149,500.8 | 1 | 300.0 | 8 | 149,500.8 | 1 | 300.0 |
| | Дүн | 9 | 149,999.3 | 4 | 315,758.9 | 13 | 465,758.2 | 4 | 315,758.9 |

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

| № | Байгууллагын ангилал | Залруулаагүй алдаа, зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах санал | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|----------------------|----------------------------|------------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|-----------------|----------------------------|----------|--|----------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | | |
| 1 | ТТЗ | 2 | 498.5 | - | - | 2 | 498.5 | - | - | 2 | - | - | - |
| 2 | ТШЗ | 7 | 149,500.8 | - | - | 1 | 81,140.3 | 4 | 67,859.0 | - | - | - | - |
| | Дүн | 9 | 149,999.3 | - | - | 3 | 82,140.3 | 4 | 67,859.0 | 2 | - | - | - |

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

| № | Байгууллагын ангилал | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | |
|---|----------------------|-----------|----------------|----------|----------------------------------|----------|
| | | | | | Тоо | Дүн |
| 1 | ТШЗ | 2 | 1 | 0 | 1 | 4 |
| 2 | ТТЗ | - | 1 | - | - | 1 |
| | Дүн | 2 | 2 | 0 | 1 | 5 |

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 429,429,619.13 | 441,412,427.83 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 47,528,367.00 | 82,591,701.00 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 47,528,367.00 | 82,591,701.00 |
| 31210 | Төгрөг | 47,528,367.00 | 82,591,701.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 47,528,367.00 | 82,591,701.00 |
| 33 | АВЛАГА | 169,431,054.00 | 126,478,799.39 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 9,078,505.00 | 1,654,827.00 |
| 33500 | Бусад авлага | 6,170,111.00 | 188,600.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 6,170,111.00 | 183,200.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 0 | 5,400.00 |
| 33600 | Зээлийн авлага | 154,182,438.00 | 124,635,372.39 |
| 33610 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 154,182,438.00 | 124,635,372.39 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 154,182,438.00 | 124,635,372.39 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 212,470,198.13 | 232,341,927.44 |
| 35100 | Түүхий эд материал | 9,091,097.86 | 9,938,897.68 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,096,596.00 | 8,096,596.00 |
| 35130 | Эм боох материал | 994,501.86 | 1,842,301.68 |
| 35400 | Хангамжийн материал | 200,739,100.27 | 220,343,029.76 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,264,035.00 | 6,234,215.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 152,736,734.62 | 162,046,582.51 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 0 | 255,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 25,022,090.15 | 33,252,990.15 |
| 35450 | Барилгын засварын материал | 500,000.00 | 500,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 10,689,042.50 | 14,369,244.10 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,527,198.00 | 3,684,398.00 |
| 35600 | Мал амьтад | 2,640,000.00 | 2,060,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,112,395,157.20 | 2,217,752,626.25 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,112,395,157.20 | 2,217,752,626.25 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,112,019,557.92 | 2,119,694,626.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,883,117,646.00 | 1,404,394,397.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -628,703,349.98 | -250,000.02 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 260,225,060.00 | 236,635,060.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -147,426,168.75 | -214,408,033.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 376,499,520.29 | 404,049,050.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -227,766,154.81 | -260,095,343.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,097,469.40 | 124,864,171.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -54,806,341.12 | -75,060,208.20 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,569,800.00 | 1,569,800.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,089,717,077.30 | 1,139,147,896.30 |

Дэлгэрэх сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--------------|---|-------------------------|-------------------------|
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -561,894,103.19 | -669,136,213.74 |
| 39217 | Ном | 24,389,102.78 | 27,984,051.10 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 375,599.28 | 98,057,999.72 |
| 39301 | Програм хангамж | 1,724,000.00 | 1,724,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,348,400.72 | -1,574,000.28 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 0 | 97,908,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,541,824,776.33 | 2,659,165,054.08 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 7,260,606.00 | 3,591,254.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 7,260,606.00 | 3,591,254.00 |
